



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2018 оны 6 дугаар сар

Тайланг бэлтгэсэн:

**Үндэсний аудитын газрын
Санхүүгийн аудитын газар**

**Газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор**

Ц.Наранчимэг

Аудитын менежер

С.Оюунгэрэл

Ахлах аудитор

**Д.Цэрэндорж
Ш.Ичинхорлоо
Г.Жавхлан**

Аудитор

**О.Баярмаа
С.Отгонхорлоо
Д.Цэгмиддорж
Ц.Энхжаргал
Б.Энхжин
С.Энхтуяа**

Гэрээт ажилтан

Э.Энхбаатар

2018 оны 6 дугаар сар

**Уг тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:**

www.audit.mn

**Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйлийн талаар 261663
дугаарын утсаар харилцана
уу.**

ХАЯГ:

**Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр
байр, Бага тойруу-3
Улаанбаатар-15160
Монгол Улс**

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	1
Нэг. Ерөнхий зүйл	2
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	3
БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ	4
БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ	6
2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж	6
2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	8
2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл	11
2.4 Монгол Улсын Засгийн газрын өр	12
БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСӨВ	16
3.1 Улсын төсвийн орлого	16
3.2 Улсын төсвийн зарлага	19
3.3 Улсын төсвийн тэнцэл	20
БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН 2017 ОНЫ ТӨСӨВ	21
4.1 Орон нутгийн төсвийн орлого	21
4.2 Орон нутгийн төсвийн зарлага	21
4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл	23
БҮЛЭГ 5. НДС-ИЙН 2017 ОНЫ ТӨСӨВ	24
5.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого	24
5.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага	24
5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл	25
БҮЛЭГ 6. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	26
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар	26
ДҮГНЭЛТ	27
ЗӨВЛӨМЖ	29
Хавсралтууд	30
Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	33

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
Ам.доллар	Америк доллар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЖДҮДС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
ЖДҮХБОХ	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчин хамгаалах
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДС	Нийгмийн даатгалын сан
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
мян.тн	мянган тонн
ОАТ	Онцгой албан татвар
ОУВС	Олон улсын валютын сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
тн	тонн
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХК	Хувьцаат компани
ХХС	Хүний хөгжил сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЭХС	Эрчим хүчний сайд

Нэг. Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2¹ дахь заалтын дагуу Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд 2018 оны 5 дугаар сарын 11-нээс 6 дугаар сарын 8-ны хооронд аудит хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7²-д заасны дагуу Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгыг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд:

- Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл
- Монгол Улсын 2017 оны төсвийн гүйцэтгэл
- Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн 2017 оны гүйцэтгэл
- Монгол Улсын Засгийн газрын өрийн талаарх танилцуулга

Танилцуулгын хавсралт мэдээлэлд:

- Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт
- Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2017 оны төсвийн гүйцэтгэл
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Улсын төсөв, Вексель, Концессын эх үүсвэр тус бүрээр/
- Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэл
- НДС, Орон нутгийн төсвийн гүйцэтгэл
- Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд, гадаад зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр
- Худалдан авах ажиллагааны тайлан
- Татварын зарлагын тайлан
- 2017 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
- ТЭЗ-дын 2017 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн тайлангийн нэгтгэлийг тус тус толилуулсан байна.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн болон Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэсэн бөгөөд Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Нэгдсэн төсвийн 2017 оны гүйцэтгэлийн аудитын тайланд Орон нутгийн төсвийн гүйцэтгэлд нэгдсэн удирдамжаар хийсэн аудитын дүнг нэгтгэлээ. Түүнчлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тусад нь аудит хийсэн тул уг тайланд оруулаагүй болно.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

¹ "төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх"

² "нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах"

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн танилцуулгад дурдсан эдийн засгийн макро түвшний үзүүлэлтүүдийг Үндэсний Статистикийн хорооноос гаргасан 2017 оны урьдчилсан гүйцэтгэл болон Монголбанкны 2017 оны жилийн тайлангаас дэлгэрүүлэн авч үзсэн болно.

ДНБ-ийн урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2017 онд 5.1 хувьд хүрч, зорилтот түвшин хангагдсан байна.

Эдийн засгийн өсөлтөд боловсруулах аж үйлдвэр 22.8 хувиар, хөдөө аж ахуй 2.3 хувиар, үйлчилгээний салбар 8.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Төлбөрийн тэнцлийн статистик үзүүлэлтүүд сайжирснаар нийт тэнцэл 1,459.9 сая ам.долларын ашигтай гарч, ашгийн хэмжээ 2016 онтой харьцуулахад 2017 онд 1,478.1 сая ам.доллараар өссөн бөгөөд гадаад худалдааны тэнцэл 1,481.0 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Тайлант онд экспорт 26.1 хувиар буюу 1,284.4 сая ам.доллараар өссөн нь голлон чулуун нүүрсний экспорт 1,288.0 сая ам.доллараар өссөнөөс голлон шалтгаалжээ.

Импорт 2017 онд 29.1 хувиар буюу 977.4 сая ам.доллараар өсөхөд Монгол Улсад орох хөрөнгө оруулалтын өсөлт, компаниудын үйл ажиллагааны сэргэлттэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын шинж чанартай бүтээгдэхүүний импорт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Инфляцийн түвшин 2017 оны 12 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.4 хувьд хүрч Монголбанкны зорилтот түвшинд нийцтэй гарчээ.

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монголбанк 2017 онд нийт 20.0 тн алт худалдаж авсан ба үүнээс 19.4 тн алтыг цэвэршүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлснээр 3,008.1 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оноос 132.0 хувиар буюу 1,711.8 сая ам.доллараар өссөн байна.

Мөнгөний бодлогын хүү 2017 оны эхэнд 14.0 хувь байснаас оны эцэст 11.0 хувь байгаа нь 3.0 нэгж хувиар буурсан байна.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, бүтээн байгуулалтад шаардагдах дотоодын болон импортын бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдан авалт нэмэгдсэн, эдийн засгийн идэвхжил сэргэсэн, НӨАТ-ын шинэчилсэн хуулийн хүрээнд татварын бааз суурь тэлсэн зэрэг голлох хүчин зүйлсийн нөлөөгөөр бүтээгдэхүүний цэвэр татвар 2017 онд бодит дүнгээр өмнөх оноос 18.6 хувиар өссөн байна.

Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжүүлж эхэлсэн болон макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, гадаад, дотоод хүчин зүйлс, уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн эерэг үзүүлэлтүүдийн нөхцөлд Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсөв хэрэгжсэн байна.

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1.1. Монгол Улсын тухайн жилийн нэгдсэн төсвийн төслийг боловсруулах, батлах харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуулиар зохицуулж байна.

1.1.2. Улсын Их Хурлаас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг 2016 оны 11 дүгээр сарын 10-нд баталжээ.

1.1.3. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "... Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална", 8.1.3-т "Улсын Их Хурал ..., дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах" гэж заасныг зөрчсөн байна.

1.1.4. Дээрх хуульд 2017 онд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулан баталсан бөгөөд эдгээрийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №1/

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл			Өөрчлөлт /өмнөх түвшнээс/	
		Анх баталсан /2016.11.10/	Нэмэлт 1 /2017.04.14/	Нэмэлт 2 /2017.10.26/	Нэмэлт 1	Нэмэлт 2
	А	1	2	3	4=2-1	5=3-2
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	3.0	(0.2)	3.3	(3.2)	3.5
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.5	6.1	7.7	(0.4)	1.6
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	6,160.2	6,035.7	6,537.1	(124.5)	501.4
	ДНБ-д эзлэх хувь	23.3	23.2	23.8	(0.1)	0.6
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	8,568.9	8,750.2	9,154.5	181.3	404.3
	ДНБ-д эзлэх хувь	32.3	33.6	33.4	1.3	(0.2)
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	(1,125.5)	(944.2)	(340.8)	181.3	603.4
	ДНБ-д эзлэх хувь	(4.2)	(3.6)	(1.2)	0.6	2.4
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(2,408.7)	(2,714.4)	(2,617.4)	(305.7)	97.0
	ДНБ-д эзлэх хувь	(9.1)	(10.4)	(9.5)	(1.3)	0.9
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,483.9	1,579.8	1,813.5	95.9	233.7
	ДНБ-д эзлэх хувь	5.6	6.1	6.6	0.5	0.5
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	22,363.7	22,144.2	23,322.3	(219.5)	1,178.1
	ДНБ-д эзлэх хувь	84.4	85.0	85.0	0.6	-
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	467.3	470.0	583.1	2.7	113.1
	ДНБ-д эзлэх хувь	1.8	1.8	2.1	-	0.3

1.1.5. Хүснэгтээс үзвэл, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг 1 жилийн дотор 3 удаа батлахдаа түүнд тусгасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг их хэмжээний өөрчлөлттэй тооцоолсон байна. Тухайлбал, 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр өмнөхөөс нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 124.5 тэрбум, Засгийн газрын өрийн нийт хэмжээг 219.5 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж баталсан боловч 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр оруулсан нэмэлтээр ДНБ-ийн бодит өсөлтийг 3.5 нэгж хувиар, үүнтэй уялдуулан орлогыг 501.4 тэрбум, өрийг 1,178.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тооцжээ.

1.1.6. Уг хуульд 2017 оны 4 дүгээр сарын 14-нд оруулсан өөрчлөлтөөр орлого болон өрийн хэмжээг бууруулахаар тооцсон боловч нэгдсэн төсвийн нийт зарлага, хөрөнгийн болон халамжийн зардлыг 2.7-181.3 тэрбум төгрөгөөр, 2 дахь нэмэлт буюу 2017 оны 10 дугаар сарын 26-нд оруулсан өөрчлөлтөөр эдгээр үзүүлэлтийг 113.1-404.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцсон байна.

1.1.7. Төсвийн төслийг боловсруулж батлах бүрт төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн нөхцөл байдалд тохируулан ийнхүү өөрчилж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “дунд хугацаа” гэж дараа жилийн болон түүний дараахь дараалсан хоёр жилийг хамарсан төсвийн гурван жилий”, 4.1.10-т “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж ... макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичгийг”, 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.1.8. Сангийн яамнаас хянасан Орон нутгийн төсвийн суурь зарлагын хэмжээг аймаг, нийслэлийн ИТХ-ууд нэмэгдүүлэн баталсан байна. Тухайлбал, Нийслэлийн 2017 оны төсвийн суурь зарлагын хэмжээг Сангийн яам 277.8 тэрбум төгрөгөөр хянасныг нийслэлийн ИТХ 352.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

1.1.9. Сангийн яамнаас Орон нутгийн нийгмийн халамжийн зардлыг 258.1 тэрбум төгрөгөөр хянасныг аймаг, нийслэлийн ИТХ нийтдээ 5.3 тэрбум төгрөгөөр бууруулан баталжээ. Тухайлбал, Нийслэл 1.5 тэрбум, Хөвсгөл 0.7 тэрбум, Өвөрхангай 0.7 тэрбум, Баян-Өлгий 0.5 тэрбум, Говь-Алтай 0.5 тэрбум, Дорнод 0.5 тэрбум, Сүхбаатар 0.3 тэрбум, Дундговь 0.2 тэрбум төгрөгөөр тус тус бууруулсан байна.

1.1.10. Иймд макро эдийн засгийн дунд хугацааны төсөөлөл, гадаад, дотоод хүчин зүйлсийг үндэслэлтэй тооцоолж, дунд хугацаанд баримтлах ТХМ-д нийцүүлж, бүх шатны төсвийн төслийг боловсруулах, төсөвт нэмэлт өөрчлөлт оруулахдаа батлагдсан хууль, суурь тооцооллыг өөрчлөх бус тууштай хэрэгжүүлэх талаар өмнөх онд Үндэсний аудитын газраас Засгийн газарт өгсөн зөвлөмж болон Улсын Их Хурлын анхааралд толилуулсан асуудлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1.11. Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн төсөв хоорондын орлого, зарлагын шилжүүлгийг 2,457.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр гарсан 2,450.2⁶ тэрбум төгрөгийн гүйлгээг цэвэрлэж тайлагнасан байна.

⁶ ЭМД-ын сангаас улсын эмнэлгүүдэд олгосон татаас 197.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 196.7 тэрбум, Орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлсэн шилжүүлэг 195.6 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 195.4 тэрбум, Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон тусгай зориулалтын болон ОНХНС-ийн шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг 1,267.8 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 1,265.3 тэрбум, НДШ-ийн зардал 225.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 222.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл тус тус гарсан бол, Улсын төсвөөс НДС-д олгосон татаас 570.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгдөж бүрэн санхүүжигдсэн байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ**2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж**

2.1.1 Улсын Их Хурал 2017 онд Монгол Улсын нэгдсэн төсөвт 2 удаа тодотгол хийж, орлогыг анх баталснаас 869.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 7,259.5 тэрбум төгрөгөөр тодотгон баталсан байна.

2.1.2 Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №2/

/тэрбум төгрөг/

№	Үзүүлэлт	2016 оны гүйц	2017 оны			
			Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
1	Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн*	5,835.0	7,259.5	7,958.3	109.6	698.8
2	Улсын төсвийн орлого	3,894.4	5,303.1	5,857.1	110.4	554.0
3	Орон нутгийн төсвийн орлого	2,169.8	2,375.5	2,437.2	102.6	61.7
4	НДС-ийн төсвийн орлого	1,999.0	2,038.2	2,114.2	103.7	76.0

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

/*Цэвэр дүнгээр/

2.1.3 Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл, төлөвлөсөн дүнгээс улсын төсвийн орлого 10.4 хувь буюу 554.0 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 2.6 хувь буюу 61.7 тэрбум, НДС-ийн орлого 3.7 хувь буюу 76.0 тэрбум төгрөгөөр тус тус илүү биелсэн байна.

2.1.4 Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлогын 56.3 хувийг улсын төсөв, 23.4 хувийг орон нутгийн төсөв, 20.3 хувийг НДС-ийн төсвийн орлого тус тус бүрдүүлсэн байна.

2.1.5 Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн хэмжээг 7,259.5 тэрбум төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,958.3 тэрбум төгрөгт хүрч, 698.8 тэрбум төгрөг буюу 9.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 2,123.3 тэрбум төгрөг буюу 36.4 хувиар тус тус давж биелсэн байна. Хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт №3/

/тэрбум төгрөг/

№	Төсвийн орлогын ангилал, зүйл	2016 оны гүйц	2017 оны				
			Анх батлагдсан	Тодотгол 2	Гүйц	Хувь	Зөрүү
	Нийт орлого ба тусламжийн дүн	5,835.0	6,390.2	7,259.5	7,958.3	109.6	698.8
	Тогтворжуулалтын сан	0.0	8.4	242.4	325.7	134.4	83.3
	Ирээдүйн өв сан	0.0	221.7	333.3	357.7	107.3	24.4
	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	5,835.0	6,160.1	6,683.8	7,274.9	108.8	591.1
I.	Татварын орлого	4,950.9	4,983.7	5,717.8	6,315.1	110.4	597.4
II.	Татварын бус орлого	884.1	1,176.4	966.0	959.8	99.3	-6.2

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

2.1.6 Нэгдсэн төсвийн 2017 оны нийт орлого ба тусламжийн дүнд нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж 91.4 хувийг, Тогтворжуулалтын сангийн орлого 4.1 хувийг, Ирээдүйн өв сангийн орлого 4.5 хувийг тус тус эзэлж байна.

2.1.7 Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 87.0 хувийг татварын, 13.0 хувийг татварын бус болон хөрөнгө, тусламжийн орлогоос тус тус бүрдүүлсэн бөгөөд татварын орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээг сүүлийн 2 жилээр харуулбал:

/Хүснэгт №4/


№	ҮЗҮҮЛЭЛТ	2016	2017
1	ДНБ, оны үнээр /тэрбум төгрөг/	23,886.4	27,167.0
2	Татварын орлого	4,950.9	6,315.1
3	Татварын ачаалал, хувь	20.7	23.2

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.


2.1.8 Хүснэгтээс үзвэл, 2017 онд ДНБ-ийн хэмжээ өмнөх оноос 3,280.6 тэрбум төгрөгөөр өсч, харин ДНБ-д эзлэх татварын ачаалал 23.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 12.1 хувь буюу 2.5 нэгж хувиар өссөн байна.

2.1.9 Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2017 онд 7,274.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 591.1 тэрбум төгрөг буюу 8.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 1,439.8 тэрбум төгрөг буюу 19.8 хувиар тус тус илүү биелсэн байна.

/График №1/



/График №2/



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

2.1.10 Тайлант онд татварын орлого 6,315.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 10.4 хувиар буюу 597.3 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 27.5 хувиар буюу 1,364.1 тэрбум төгрөгөөр тус тус илүү биелсэн ба татварын бүх төрлөөр орлого төлөвлөснөөс 1.2-21.4 хувь буюу 0.5-258.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

2.1.11 Төсвийн орлогын төлөвлөгөөнд зэс, алт, коксжих болон боловсруулсан чулуун нүүрс, цайрын тэнцвэржүүлсэн үнэ, биет хэмжээг доорх хүснэгтэд үзүүлснээр тооцож, уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний борлуулалтаас орох татварын нийт орлогыг 762.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 847.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 11.2 хувиар буюу 85.2 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.


/Хүснэгт №5/

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Биет хэмжээ		Үнэ, (ам.доллар/тн)		Нийт орлого (тэрбум төгрөг)	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Алт /тн/	17.0	17.5	1,255.0	1,257.2	41.2	15.6
2	Нүүрс /мян.тн/	32,038.8	33,400.5	59.1	68.4	256.1	269.1
3	Зэсийн баяжмал /мян.тн/	1,371.3	1,447.2	6,030.0	6,162.3	413.9	479.5
4	Цайрын баяжмал /мян.тн/	100.0	118.2	1,765.5	1,529.4	18.0	23.8
5	Жонш, жоншны баяжмал /мян.тн/	298.5	319.3	276.7	263.7	7.0	7.6
6	Бусад					26.3	52.1
НИЙТ ДҮН						762.5	847.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

2.1.12 Уул уурхайн салбараас 2017 онд улсын төсөвт төвлөрүүлсэн АМНАТ-ийн 88.3 хувийг зэс, нүүрсний салбарын, 11.7 хувийг бусад уул уурхайн бүтээгдэхүүний татварын орлого тус тус эзэлж байна. Үүний 56.6 хувь буюу 479.5 тэрбум төгрөг нь зэсийн баяжмал, 31.7 хувь буюу 269.1 тэрбум төгрөг нь нүүрсний үйлдвэрлэлээс төвлөрчээ.

2.1.13 Уул уурхайн голлох эрдэс бүтээгдэхүүний борлуулалтыг графикаар харуулбал:



2.1.14 Тайлант онд татварын орлого 10.4 хувиар давж биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд:

- Уул уурхайн голлох эрдэс бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний үнэ болон экспортын биет хэмжээ нэмэгдсэн;
- Татвар төлөгч аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого, ашигт ажиллагааны түвшин өссөн;
- Нийт бараа эргэлтийн хэмжээ /экспорт, импорт/ өмнөх оноос 27.3 хувиар буюу 2.3 тэрбум ам.доллараар өсч, импортын барааны НӨАТ, гаалийн болон онцгой албан татварын орлого тус тус давж биелсэн байна.

. Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав

2.1.15 Тайлант онд уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ болон биет хэмжээ өссөн нь АМНАТ-аас Төсвийн тогтворжуулалтын санд 297.4 тэрбум, Ирээдүйн өв санд 357.7 тэрбум, улсын төсөвт 192.6 тэрбум, нийт 847.7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэх боломжийг бий болгосон байна.

2.1.16 Зэс, нүүрсний зах зээлийн үнэ 2017 оны турш тэнцвэржүүлсэн үнээс дээгүүр байснаар дээрх 2 санд нийт 683.4 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулсан нь төлөвлөснөөс 107.6 тэрбум төгрөгөөр давж биелэхэд нөлөөлжээ.

2.1.17 Зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш зэрэг эрдэс бүтээгдэхүүний үнийн болон биет хэмжээний өсөлтөөс хамаарч уул уурхайн салбараас тайлант онд 1,827.3 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн нь төсвийн орлогын 23.0 хувийг эзэлж, энэ нь өмнөх оноос 7.0 нэгж хувиар өссөн байна.

2.1.18 Татварын бус орлогоор 959.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оноос 8.6 хувиар буюу 75.7 тэрбум төгрөгөөр өссөн боловч төлөвлөснөөс 0.7 хувиар буюу 6.2 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

2.1.19 Татварын бус орлого дутуу төвлөрөхөд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Тухайлбал, төлөвлөснөөс:


- Хувьцааны ногдол ашгийн орлого 7.7 тэрбум төгрөг буюу 17.7 хувиар,
- Хөрөнгийн орлого 0.01 тэрбум төгрөг буюу 0.8 хувиар,
- Төсөвт байгууллагуудын өөрийн орлого 34.9 тэрбум төгрөгөөр буюу 9.3 хувиар,
- Тусламжийн орлого 14.8 тэрбум төгрөгөөр буюу 19.3 хувиар тус тус тасарсан байна.

2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл

/График №4/

2.2.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг анх 8,568.9 тэрбум төгрөгөөр баталсан ба тайлант онд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулан 181.3-404.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

2.2.2 Төсвийн нэгдмэл байдлыг бодитойгоор хангах, сахилга батыг чангатгах, төсвийн зарлагын үр ашгийг сайжруулах замаар төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулахтай холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай хамтран



“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн нь ТХМ-д тусгасан үзүүлэлтүүдийг шинэчлэх шаардлага бий болжээ.

2.2.3 Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 201 дүгээр тогтоолоор “... Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт өрхийн хүүхэд бүрт, ... 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож ...” хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгох болсон тул зардлыг төсөвт тусгах шаардлагатай болсноор 104.5 тэрбум төгрөгийг нэмж тусгасан байна.

2.2.4 Эрчим хүч, эрүүл мэнд, барилга, хот байгуулалт, зам тээврийн салбарт 85.4 тэрбум, шүүхийн шийдвэртэй буюу Засгийн газрын тогтоол шийдвэрийн дагуу төлөгдөх хөрөнгө оруулалтын шинжтэй дотоод өр төлбөрийг барагдуулах зардал 57.9 тэрбум, шинээр батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон эрүүл мэнд, нийгмийн салбарт зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж зэрэгт 49.8 тэрбум, бусад салбарт 40.6 тэрбум, нийт 233.7 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэхээр тооцсон байна.

2.2.5 Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө 9,494.4 тэрбум төгрөгийг 2017 оны ТХМ-ээр баталсан 9,154.5 тэрбум төгрөгтэй харьцуулахад 339.9 тэрбум төгрөг буюу 3.7 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь орон нутгийн ИТХ-аас эцэслэн баталсан төсвийн нийт зарлага Сангийн яамны хянасан суурь зарлагаас 346.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.2.6 Орон нутгийн ТЕЗ-дын дүнгээр бараа, үйлчилгээний зардлыг 187.6 тэрбум, татаас ба урсгал шилжүүлгийг 52.6 тэрбум, хөрөнгийн зардлыг 91.5 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 14.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

2.2.7 Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл 9,017.3 тэрбум төгрөгт хүрч, 95.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.8 Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө гүйцэтгэлийг бүтцээр нь харуулбал:

/Хүснэгт №6/ ҮЗҮҮЛЭЛТ		2016 оны гүйц	/тэрбум төгрөг/ 2017 оны			
			Төлөв	Гүйц	хувь	дүн
1		2	3	4	5=4/3	6=4-3
НЭГДСЭН ТӨСӨВ*		9,495.3	9,494.4	9,017.3	95.0	-477.1
Улсын төсөв		7,394.2	7,420.6	7,139.6	96.2	-281.0
Орон нутгийн төсөв		2,330.4	2,623.5	2,437.1	92.9	-186.4
Хүний хөгжил сангийн төсөв		278.6	0.0	0.0	0.0	0.0
НДС-ийн төсөв		1,720.3	1,907.5	1,890.9	99.1	-16.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

/*Цэвэр дүнгээр/

2.2.9 Улсын төсвийн зарлага 7,139.6 тэрбум төгрөг буюу 96.2 хувийн, орон нутгийн төсвийн зарлага 2,437.1 тэрбум төгрөг буюу 92.9 хувийн, НДС-ийн төсвийн зарлага 1,890.9 тэрбум төгрөг буюу 99.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.10 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

/Хүснэгт №7/ Үзүүлэлт		2016 оны гүйц	/тэрбум төгрөг/ 2017 оны		Зөрүү	
			Төлөв	Гүйц	Хувь	Дүн
1		3	4	5	6=5/4	7=5-4
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн*		9,495.3	9,494.4	9,017.3	95.0	-477.1
А Урсгал зарлага		6,613.8	7,235.7	7,043.2	97.3	-192.5
1	Бараа, үйлчилгээний зардал	3,133.3	3,269.5	3,141.4	96.1	-128.1
2	Хүү	986.1	1,156.7	1,156.5	100.0	-0.2

	3	Татаас ба урсгал шилжүүлэг	2,494.4	2,809.5	2,745.3	97.7	-64.2
Б		Хөрөнгийн зардал	2,360.2	1,904.9	1,658.1	87.0	-246.8
В		Эргэж төлөгдөх цэвэр зээл	521.3	353.8	316.0	89.3	-37.8

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

/*Цэвэр дүнгээр/

2.2.11 Хүснэгтээс үзвэл, Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл төлөвлөснөөс 477.1 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь урсгал зарлагыг 192.5 тэрбум, хөрөнгийн зардлыг 246.8 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардлыг 37.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

2.2.12 Урсгал зарлага 7,043.2 тэрбум төгрөг буюу 97.3 хувийн, хөрөнгийн зардал 1,658.1 тэрбум төгрөг буюу 87.0 хувийн, эргэж төлөгдөх цэвэр зээл 316.0 тэрбум төгрөг буюу 89.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.13 Бараа, үйлчилгээний зардал 128.1 тэрбум, татаас ба урсгал шилжүүлгийн зардал 64.2 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь урсгал зарлагын хэмнэлтэд нөлөөлжээ.

2.2.14 Хөрөнгийн зардал 1,658.1 тэрбум төгрөг буюу 87.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөснөөс 246.8 тэрбум төгрөг буюу 13.0 хувиар бага байна.

2.2.15 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардал 353.8 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 316.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2.2.16 Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар 8 ТЕЗ-д нийт 471.3 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээлийг олгож, өмнөх онуудад олгосон зээлээс 155.3 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Хүснэгтээр харуулбал:

Төсвийн ерөнхийлөн захирагч		Төсөл хөтөлбөрийн нэр	2017 оны		Зөрүү
			Төлөв	Гүйц	
Олгосон зээл, үүнээс			547.8	471.3	(76.5)
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	Боловсролын зээлийн сан		63.1	22.7	(40.4)
Сангийн сайд	Олгох зээл /10 төсөл, арга хэмжээ/		199.1	229.0	29.9
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" сан		20.0	20.0	0
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан		49.8	49.8	0
	Мал хамгаалах сан		41.9	41.0	(0.9)
	Тариалан эрхлэлтийг дэмжих сан		21.4	43.8	22.4
	Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл		0.9	0.8	(0.1)
	ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл		0.1		(0.1)
Барилга, хот байгуулалтын сайд	Улаанбаатар хотын VII, XIV хорооллын орон сууцны хорооллын болон Замын үүдийн дэд бүтэц, зүүн өмнөд, говийн хот, хил орчим хотын хөгжил төсөл		21.7	0	(21.7)
Зам, тээврийн хөгжлийн сайд	Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл		6.5	0	(6.5)
Эрчим хүчний сайд	Олгох зээл /3 төсөл, арга хэмжээ/		78.5	41.2	(37.3)
Орон нутгийн төсөв захирагчид	15 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид		44.8	23.0	(21.8)
Буцаан төлөгдсөн зээл, үүнээс			(194.0)	(155.3)	(38.7)
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	ЖДҮДС: ЗГҮЦ, дамжуулан зээл		(52.0)	(11.3)	(40.7)
Хууль зүй, дотоод хэргийн сайд	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба		(20.6)	0	(20.6)
Сангийн сайд	ААНБ болон улс, орон нутгийн төсөвт байгууллагууд, төсөл		(121.4)	(144.0)	22.6
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн			353.8	316.0	(37.8)

2.2.17 Тайлант онд Сангийн сайд, БСШУСС, ХХААХҮС, ЭХС болон орон нутгийн ТЕЗ-д нийт 461.8 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 351.6 тэрбум төгрөг байна. Тухайлбал, УБ-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл 39.5 тэрбум, Оюутны хөгжлийн зээл 39.3 тэрбум, 15 аймгийн ТЕЗ-д 21.8 тэрбум, ХАА-н хөдөөгийн төсөл нэмэлт санхүүжилт 5.3 тэрбум, бусад 4.3 тэрбум төгрөг байна.

2.2.18 Зарим төслүүдэд 56.9 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 119.6 тэрбум төгрөгт хүрч, 62.7 тэрбум төгрөгөөр хэтэрчээ. Тухайлбал, Тариалан эрхлэлтийг дэмжих сан 22.4 тэрбум, ЖДҮХБОХ 2 шаттай төслийн дамжуулан зээл 19.2 тэрбум, Экспортын шугам нээх төсөл 17.7 тэрбум, ДЦС-4 үр ашиг дээшлүүлэх төсөл 3.5 тэрбум төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

2.2.19 БХБС 21.7 тэрбум, ЗТХС 6.5 тэрбум, Зээлийн батлан даалтын дүрмийн санд 0.9 тэрбум, ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөлд 0.1 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэл гараагүй байна.

2.2.20 Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зээлийн төлөвлөгөөг 38.7 тэрбум төгрөгөөр буюу 20.0 хувиар дутуу биелүүлсэн байна. Тухайлбал,

Хууль зүй, дотоод хэргийн сайд-ТЕЗ:

Хадгаламж зээлийн хоршоодод мөнгөө хадгалуулсан иргэдэд учирсан хохиролд төсвөөс олгосон зээлийн 20.6 тэрбум төгрөгийн авлага хуульд орсон өөрчлөлтийн улмаас эргэн төлөгдөх нь эрсдэлтэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд-ТЕЗ:

ЖДҮДС: ЗГҮЦ, дамжуулан зээлийн үлдэгдэл 40.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлээгүй байгаа нь Капитал банкны 50.0 тэрбум төгрөгийн зээлийн гэрээний хугацааг сунгасантай холбоотой байна.

Сангийн сайд-ТЕЗ: ААНБ болон улс, орон нутгийн төсөвт байгууллагууд, төслүүд 22.6 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс илүү төвлөрүүлсэн байна.

2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл

2.3.1 Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,810.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,742.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу 1,068.1 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 2.1 дахин буурч, ДНБ-ийн 6.4 хувийг эзэлж байна. Үүнийг төсвийн бүтцээр харуулбал:

/Хүснэгт №9/ Үзүүлэлт	2016 оны гүйц	/тэрбум төгрөг/ 2017 оны		
		Төлөв	Гүйц	Зөрүү
Нэгдсэн төсөв	(3,660.3)	(2,810.6)	(1,742.5)	1,068.1
Улсын төсөв	(3,499.8)	(2,693.3)	(1,966.0)	727.3
Орон нутгийн төсөв	(160.6)	(248.0)	0.1	248.1
НДС-ийн төсөв	89.6	130.7	223.4	92.7
Хүний хөгжил сан	(89.5)	0	0	0

2.3.2 Хүснэгтээс үзвэл, Тайлант онд төлөвлөснөөс улсын төсвийн алдагдал 727.3 тэрбум төгрөгөөр буурч, НДС-ийн төсвийн тэнцлийн ашиг 92.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн төсвийг 248.0 тэрбум төгрөгийн алдагдалтай төлөвлөснөөс 0.1 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь нэгдсэн төсвийн нийт алдагдал 1,068.1 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

2.3.3 Нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор тайлант онд 6,589.2 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалж, 2,229.6 тэрбум төгрөгийн гадаад зээл авч, Тогтворжуулалтын сангаас 572.1 тэрбум төгрөг, Ирээдүйн өв сангаас 160.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт шилжүүлж, Ирээдүйн өв сангийн 196.9 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулж, өмч хувьчлалын орлого 22.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

2.3.4 Дээрх эх үүсвэрүүдээс ЗГҮЦ-ны эргэн төлөлтөд 6,382.6 тэрбум, Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтөд 165.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, төсвөөс эргэн төлөгдөх 466.5 тэрбум төгрөгийг төлж, 1,742.5 тэрбум төгрөгөөр 2017 оны нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлснээр харилцах болон хадгаламжийн дансдын үлдэгдэл 1,013.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2.4 Монгол Улсын Засгийн газрын өр

2.4.1 УИХ-аас 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдөр Өрийн удирдлагын тухай хуулийг батласантай холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан “Улсын өр” тодорхойлолтыг “Засгийн газрын өр”⁸ гэж өөрчлөн хамрах хүрээг өөрчилсөн байна. Өрийн /нэрлэсэн үнээрх/ нийт үлдэгдлийг сүүлийн 2 жилийн байдлаар харуулбал:

/Хүснэгт №10/

/тэрбум төгрөг/

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БҮТЭЦ	2016.12.31	2017.12.31	Өөрчлөлт	Дүнд эзлэх хувь
I. Засгийн газрын дотоод өр	6,464.9	4,230.1	-2,234.8	18.6
1.1 Үнэт цаас	5,488.8	3,461.9	-2,026.9	15.2
1.2 Өрийн бичиг/вексель	307.2	0.0	-307.2	0.0
1.3 Концесс	668.9	768.2	99.3	3.4
II. Засгийн газрын гадаад өр	12,363.8	16,857.8	4,494.0	74.1
2.1 Үнэт цаас	5,380.5	7,701.6	2,321.1	33.9
2.2 Зээл	6,983.3	9,156.2	2,172.9	40.2
III. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг	3,451.5	1,663.7	-1,787.8	7.3
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	3,451.5	1,663.7	-1,787.8	7.3
Засгийн газрын нийт өр (I+II+III)	22,280.2	22,751.6	471.4	100.0
Засгийн газрын өр (ӨҮЦ)	18,861.0	20,212.1	1,351.1	
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	88.0%	85.0%	-3.0%	
Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ	78.8%	74.4%	-4.4%	

2.4.2 Хүснэгтээс үзвэл, Засгийн газрын 2017 оны өрийн үлдэгдлийн 81.4 хувийг гадаад, 18.6 хувийг дотоод өр эзэлж буйг 2016 оны түвшинтэй харьцуулбал өрийн бүтцэд томоохон өөрчлөлт орсон байна.

2.4.3 ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй эх үүсвэрээр төсвийн алдагдлыг нөхөж, дотоодын өндөр хүүтэй ЗГҮЦ гаргалтыг зогсоосон нь Засгийн газрын өрийн (өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн) ДНБ-д эзлэх харьцааг бууруулахад нөлөөлснөөр өрийн бүтцэд гадаад өрийн эзлэх хувь өсч, дотоод өрийн эзлэх хувь буурсан байна.

2.4.4 Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2016 онд 78.8 хувь байсан бол 2017 оны эцэст 74.4 хувь болж буурсан бөгөөд энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон хязгаар 85.0 хувиас хэтрээгүй байна.

2.4.5 Засгийн газрын гадаад өрийн бүтэц нь гадаад хөнгөлөлттэй зээл болон үнэт цаас, өрийн баталгаанаас бүрдэж байна.

/Хүснэгт №11/

/тэрбум төгрөг/

Гадаад өрийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хувь	Хүүгийн зардал
Гадаад зээл	6,983.3	2,229.6	165.2	108.5	9,156.2	49.4	113.6
Гадаад үнэт цаас	5,380.5	3,445.1	950.8	-173.2	7,701.6	41.6	408.5
Өрийн баталгаа	3,451.5	4.0	1,757.3	-34.5	1,663.7	9.0	
Нийт дүн	15,815.3	5,678.7	2,873.3	-99.2	18,521.5	100.0	522.1

⁸ орон нутгийн өмчит болон орон нутгийн өмч давамгайлсан, төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжүүдийн өрийг оруулахгүй болсон

2.4.6 Засгийн газрын гадаад валютаар илэрхийлэгдэж байгаа өрийн багцад ам.доллар 31.9 хувийг, зээлжих тусгай эрх 31.7 хувийг, иен 28.0 хувийг, евро 5.2 хувийг, бусад валют 3.2 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд тайлант оны эцсийн үлдэгдлийн 1 ам.долларын ханшийг 2,427.13 төгрөгөөр тооцон илэрхийлсэн байна.

2.4.7 Гадаад зээл Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл өмнөх онд 6,983.3 тэрбум төгрөг байснаас тайлант онд 9,156.2 тэрбум төгрөгт хүрч, 2,172.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

/Хүснэгт №12/		/тэрбум төгрөг/				
Гадаад зээлийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хувь
Төслийн зээл	5,676.7	751.5	164.5	132.8	6,396.5	69.8
Хөтөлбөрийн зээл	709.1	1,478.1	0.7	-9.3	2,177.2	23.8
Арилжааны зээл	597.5	0.0	0.0	-15.0	582.5	6.4
Нийт гадаад зээл	6,983.3	2,229.6	165.2	108.5	9,156.2	100.0

2.4.8 Монгол Улсын Засгийн газар гадаад орон, олон улсын банк, санхүүгийн 11 байгууллагаас 61 төсөлд 2017 онд 915.4 сая ам.доллар буюу 2,229.6 тэрбум төгрөгийн гадаад зээлийг авч ашигласан нь өмнөх оноос 879.6 тэрбум төгрөгөөр илүү байна. Гадаад зээлийн ашиглалтын 1,478.1 тэрбум төгрөг буюу 66.3 хувь нь хөтөлбөрийн зээл, 751.5 тэрбум төгрөг буюу 33.7 хувь нь төслийн зээл байна.

2.4.9 Гадаад зээлийн үндсэн төлбөрт 165.2 тэрбум төгрөгийг төлж, 2017 оны жилийн эцсийн үлдэгдэл 3,772.4 сая ам.доллар буюу 9,156.2⁹ тэрбум төгрөг байна.

2.4.10 Гадаад үнэт цаас Засгийн газрын гадаад үнэт цаас нь нийт өрийн багцын 33.9 хувийг эзэлж байгаа бөгөөд 2017 онд олон улсын зах зээлд 1,400.0 сая ам.доллар буюу 3,445.1 тэрбум төгрөгийн Хуралдай, Гэрэгэ бондыг тус тус арилжаалж, Монгол Улсын Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын евро бондыг төлж, Чингис¹⁰ болон Дим сам¹¹ бондын заримыг буцаан худалдан авч, нийт гадаад үнэт цаасны оны эцсийн үлдэгдэл 3,171.1 сая ам.доллар буюу 7,701.6 тэрбум төгрөг байна. Үнэт цаасны төрлөөр хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт №13/		/тэрбум төгрөг/							
Гадаад үнэт цаасны нэр	Гаргасан огноо	Хүүгийн түвшин хувиар	Зээлийн дүн сая/ам.дол	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Үндсэн төлбөр	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр
Чингис бонд - 12-0.5	12/5/2012	4.125	500.0	1,244.8	0.0	915.6	-20.4	308.8	62.1
Чингис бонд - 12-1.0	12/5/2012	5.125	1,000.0	2,489.5	0.0	0.0	-62.4	2,427.1	124.1
Дим сам бонд	6/30/2016	5.960	161.2	401.4	0.0	35.2	-12.0	354.2	24.9
Мазаалай бонд -0.5	4/06/2017	10.875	500.0	1,244.8	0.0	0.0	-31.2	1,213.6	133.5
Хуралдай бонд -0.6	3/09/2017	8.750	600.0	0.0	1,480.1		-23.9	1,456.2	63.9
Гэрэгэ бонд -0.8	1/11/2017	5.625	800.0	0.0	1,965.0		-23.3	1,941.7	
НИЙТ ДҮН				5,380.5	3,445.1	950.8	-173.2	7,701.6	408.5

2.4.11 Гадаад бондын хүүгийн төлбөрт тайлант жилд 167.9 сая ам.доллар буюу 408.5 тэрбум төгрөгийг төлсөн байна.

⁹ Монголбанкнаас зарласан 2017 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 1 ам.долларын ханш 2,427.13 төгрөг болно.

¹⁰ 2012 оны 12 дугаар сард 10 жилийн хугацаатай 1.0 тэрбум ам.долларын бондыг 5.125 хувийн хүүтэйгээр, 5 жилийн хугацаатай 500.0 сая ам.долларын бондыг 4.125 хувийн хүүтэйгээр, нийт 1.5 тэрбум ам.долларын Чингис бондыг олон улсын зах зээлд арилжаалсан.

¹¹ Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор олон улсын зах зээлд 3.5 жилийн хугацаатай, 350 сая хүртэл ам.доллартай тэнцэх хэмжээний юаниар илэрхийлсэн ЗГҮЦ гаргахаар шийдвэрлэсний дагуу арилжсан 3 жилийн хугацаатай 1.0 тэрбум юаньтай тэнцэх үнэт цаас

/Хүснэгт №14/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Хүүгийн түвшин	Нэрлэсэн	Солилцсон	Арилжсан	Хугацаа /жилээр/	Хүүгийн түвшин	Тайлбар
Монгол Улсын Хөгжлийн банк /евро бонд/	5,750	580.0	580.0	476.0	7	8.750	Хуралдай бондоор солилцсон
				124.0		7.625	Олон улсын зах зээлд арилжаалсан
Дүн		580.0	580.0	600.0			
Чингис бонд /12-0.5/	4.125	500.0	372.8	800.0	5.5	5.625	Гэрэгэ бондоор солилцсон
Дим сам бонд	5.960	161.2	14.3				
Дүн		661.2	387.1				
Бусад*			412.9				
Дүн		661.2	800.0	800.0			

2.4.11 Монгол Улсын Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын бондыг 7 жилийн хугацаатай, 8.750 хувийн хүүтэй 600.0 сая ам.долларын Хуралдай бондоор сольсон байна.

2.4.12 Олон улсын зах зээлд 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр арилжаалсан 5.5 жилийн хугацаатай 5.625 хувийн хүүтэй 800.0 сая ам.долларын Гэрэгэ бондын 387.1 сая ам.долларыг, Чингис бондын 2018 оны 1 дүгээр сард төлөгдөх 500.0 сая ам.долларын 74.5 хувь, 2018 оны 6 дугаар сард төлөгдөх 1.0 тэрбум юанийн Дим сам бондын 9.5 хувийг буцаан худалдан авахад зарцуулсан байна.

2.4.13 Үнэт цаасны солилцоотой холбоотойгоор хуримтлагдсан хүүгийн төлбөрт 5.3 сая, Чингис болон Дим сам бондыг буцаан худалдан авах шимтгэлд 1.5 сая, холбогдох бусад зардалд 3.9 сая ам.долларыг тус тус төлж, Гэрэгэ бондоос улсын төсвийн дансанд 402.2 сая ам.доллар орсон байна.

2.4.14 Чингис, Дим сам бондын үндсэн төлбөрийн үлдэгдэл 273.1 сая ам.долларыг 2018 онд төлөхөөр байна.

- Чингис бондын 127.2 сая ам.долларыг 2018 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр төлсөн бөгөөд
- Дим сам бондын 145.9 сая ам.доллар 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдөр төлөгдөхөөр байна.

2.4.15 Өрийн баталгаа Засгийн газрын өрийн баталгаа тайлант оны эцэст 1,663.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгааг 2016 онтой харьцуулахад 2.1 дахин буурсан байна. Бүтцийг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт №15/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Ашиг-лалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Эзлэх хувь
Засгийн газрын баталгаа						
Хөгжлийн банк	3,229.8	0.0	1,729.0	(29.2)	1,471.6	88.5
"МИАТ" ТӨХК	208.6	0.0	28.3	(5.0)	175.3	10.5
"Эрдэнэс Монгол" ХХК	13.1	4.0	0.0	(0.3)	16.8	1.0
Өрийн баталгааны дүн	3,451.5	4.0	1,757.3	(34.5)	1,663.7	100.0

2.4.16 Хөгжлийн банкны өрийн баталгааг авч үзвэл,

- Самурай бонд 30.0 тэрбум иен буюу 645.9 тэрбум,
- БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл 162.0 сая ам.доллар буюу 327.7 тэрбум,
- Кредит Свисс банкны зээл 300.0 сая ам.доллар буюу 498.0 тэрбум төгрөг байна.

2.4.17 "Боинг" нисэх онгоц худалдан авсан "МИАТ" ТӨХК-ийн зээлд гаргасан өрийн баталгаанаас 2017 оны эргэн төлөлт 28.3 тэрбум төгрөгийг хорогдуулж, ханшийн өөрчлөлт 5.0 тэрбум төгрөгөөр буурч 72.2 сая ам.доллар буюу 175.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.4.18 “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн нийт 42.0 сая ам.долларын санхүүжилт бүхий төслийн 85.0 хувь буюу АХБ-аас авсан 35.0 сая ам.долларын зээлд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа тайлант оны ашиглалт 4.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, ханшийн зөрүү 0.3 тэрбум төгрөгөөр хорогдож, 6.9 сая ам.доллар буюу 16.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.4.19 Дотоод үнэт цаас Тайлант оны эхэнд Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 5,488.8 тэрбум төгрөг байснаас төсвийн орлогын улирлын чанартай дутагдлыг нөхөх зорилгоор нийт 3,376.6 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалж, 5,403.5 тэрбум төгрөгийг эргэн төлж, оны эцэст 3,461.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. ЗГҮЦ-ны үлдэгдлийн бууралтад:

- 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс хойш Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалаагүй,
- 16-18 хувийн хүүтэй байсан Засгийн газрын дотоод үнэт цааснаас 370.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авсан нь тус тус нөлөөлжээ.

2.4.20 Ингэснээр Засгийн газрын дотоод үнэт цаасны дундаж хүү 2016 оны эцэст 18 хувьд хүрээд байсан бол 2017 оны эцэст 8-10 хувьд хүрэх нөхцөл бүрдсэн байна.

2.4.21 Концесс Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7-д¹⁷ заасны дагуу төсвөөс эргэн төлөх концессын өр 2017 оны эхэнд 668.9 тэрбум төгрөг байснаас тайлант жилийн ашиглалт 99.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 768.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй (барих-шилжүүлэх төрөл) нийт 26 концессын гэрээний хүрээнд гарсан ашиглалт 750.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй нийт 18 гэрээний дагуу төлөх төлбөрийн үүрэг 17.3 тэрбум төгрөг байна.

2.4.22 Вексель Өмнөх онуудад үүссэн хөрөнгө оруулалтын өрийн бичгийн оны эхний үлдэгдэл 307.2 тэрбум төгрөгийг тайлангийн хугацаанд төлж барагдуулсан байна.

2.4.23 Засгийн газрын дотоод өрийн оны эхний нийт үлдэгдэл 6,464.9 тэрбум төгрөг байснаас оны эцэст 4,230.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 2,234.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

¹⁷ “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ”

БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСӨВ

3.1 Улсын төсвийн орлого

3.1.1 Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 5,303.0 тэрбум төгрөгөөр төлөвлөж, 5,857.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 10.4 хувь буюу 554.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

3.1.2 Улсын төсвийн 2017 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг харуулбал:

/Хүснэгт №16/

/тэрбум төгрөг/

№	Төсвийн орлогын ангилал, зүйл	2016 оны гүйц	2017 он			
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
I	Нийт орлого ба тусламжийн дүн	3,894.4	5,303.0	5,857.1	554.1	110.4
II	Тогтворжуулалтын сан		242.4	325.7	83.3	134.4
III	Ирээдүйн өв сан		333.3	357.7	24.4	107.3
IV	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	3,894.4	4,727.3	5,173.7	446.4	109.4
1	Татварын орлого	2,854.1	3,527.6	3,987.2	459.6	113.0
1.1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	520.0	728.7	962.1	233.4	132.0
1.2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,140.7	1,448.5	1,618.5	170.0	111.7
1.3	Онцгой албан татвар	630.1	511.6	519.7	8.1	101.6
1.4	Тусгай зориулалтын орлого	10.8	11.9	12.4	0.4	104.2
1.5	Гадаад үйл ажиллагааны орлого	328.5	489.8	512.4	22.6	104.6
1.6	Бусад татвар	224.0	337.1	362.1	25.0	107.4
2	Татварын бус орлого	1,040.3	1,199.7	1,186.5	-13.2	98.9

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

3.1.3 Монгол Улсын 2017 оны төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн гүйцэтгэл 5,173.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 9.4 хувиар буюу 446.4 тэрбум, өмнөх оноос 50.4 хувь буюу 1,279.3 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

3.1.4 Монгол Улсын 2017 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнгийн 77.1 хувь нь татварын орлогоос, 22.9 хувь нь татварын бус орлогоос бүрдсэн байна.

3.1.5 Тайлант оны татварын орлого бүх нэр төрлөөрөө 0.3-40.6 хувиар буюу 0.4-233.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Хүснэгт №17/

Үзүүлэлт	2016 он	2017 он
ДНБ-ийн бодит өсөлт /хувь/	3.1	5.1
Экспорт /сая ам. доллар /	4,916.3	6,200.7
Импорт /сая ам. доллар /	3,358.1	4,335.5

Эх сурвалж: Сангийн яам болон Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд суурилав.

3.1.6 Тайлант онд татварын орлого нэр төрлөөрөө давж биелэхэд уул уурхайн голлох эрдэс бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний үнэ болон биет хэмжээ өсч, ААНБ-дын орлого, ашгийн хэмжээ нэмэгдсэнээр ААНОАТ, нийт бараа эргэлт 27.3 хувь, импортын бараа 27.4 хувиар өссөнөөр гадаад үйл ажиллагааны болон импортын НӨАТ-ын орлого тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.1.7 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого тайлант онд 962.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 32.0 хувиар буюу 233.4 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 85.0 хувиар буюу 442.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелэхэд татвар төлөгчдийн тоо өмнөх оноос 11.3 мянгаар, ногдолтой тайлан 5.8 хувиар тус тус өсч, алдагдалтай тайлан 2.7 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №18/

Үзүүлэлт	2016 он	2017 он
Тайлан ирүүлбэл зохих татвар төлөгч	121,209	132,513
Тайлан ирүүлсэн татвар төлөгч	88,258	91,525
"Х" тайлан	37,692	39,506
Алдагдалтай тайлан	17,486	17,013
Ногдолтой тайлан	33,080	35,006
Тайлан ирүүлээгүй татвар төлөгч	32,951	41,050
Ирц хувь	72.8	69.1

*Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

3.1.8 Нэмэгдсэн өртгийн албан татвараар улсын төсөвт 2017 онд 1,448.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 1,618.5 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 170.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн ба өмнөх оны гүйцэтгэлээс 11.7 хувь буюу 477.8 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. НӨАТ-ын 45.4 хувийг дотоодын барааны, 54.6 хувийг импортын барааны татвар эзэлж байна.

3.1.9 Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олгоолтоор 2017 онд 157.2 тэрбум төгрөг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 147.5 тэрбум төгрөг олгосон байна.

3.1.10 НӨАТ-ын буцаан олголтын судалгааг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №19/			/тэрбум төгрөг/			
НӨАТ-ын 2 хувийн буцаан олголт	ААНБ		НӨАТ-ын сугалааны тохирлын урамшуулалд	Гадаадын элчин сайдын яам	Гадаадын төлөөлөгчийн газар	Нийт дүн
	Буцаан олгосон	Татварт суутган тооцсон				
35.5	18.9	83.9	5.6	1.7	1.9	147.5

3.1.11 Хүснэгтээс үзвэл, НӨАТ-ын буцаан олголт 2017 онд 31 ААНБ-д 102.8 тэрбум, татвар төлөгч 620.4 мянган иргэнд 35.5 тэрбум, НӨАТ-ын сугалааны тохирлоор 5.6 тэрбум, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын ДТГ, Төлөөлөгчийн газруудад 3.6 тэрбум төгрөгийг тус тус олгожээ.

3.1.12 НӨАТ-ын илүү төлөлтийн 63.6 тэрбум төгрөг буюу 43.3 хувийг буцаан олгож, 83.9 тэрбум төгрөг буюу 56.7 хувийг ААНБ-ын бусад татваруудад шилжүүлж суутган тооцсон байна.

3.1.13 НӨАТ-ын илүү төлөлтийн 102.8 тэрбум төгрөгийн 95.6 хувийг нэр бүхий 3 ААНБ-д тооцож олгосноос 18.0 тэрбум төгрөгийг буцаан олгож, 80.3 тэрбум төгрөгийг бусад татварт шилжүүлэн тооцсон байна.

3.1.14 Татварын ерөнхий газар НӨАТ-ын илүү төлөлтийг хянан баталгаажуулахдаа татварын хяналт шалгалт хийх томилолт, ажлын удирдамжид тусгагдаагүй өмнөх онуудын илүү төлөлтийг хамруулсан, ААНБ-дын баталгаажуулалтад хамрагдах хугацааны борлуулалтын орлого, худалдан авалтын харьцаанд дүгнэлт хийгээгүй байна.

3.1.15 Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 2017 онд 124.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь төлөвлөснөөс 20.0 хувиар буюу 31.2 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн, өмнөх оноос 61.1 хувиар буюу 196.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

3.1.16 Тайлант онд Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хувь хэмжээг Засгийн газрын 2017 оны 34 дүгээр тогтоолоор өмнөх хувь хэмжээнээс 3 дахин бууруулж 40.0 тэрбум төгрөгийн татвар ногдуулсан бол 207 дугаар тогтоолоор нэмэгдүүлж 76.5 тэрбум, 309 дүгээр тогтоолоор дахин бууруулж 21.8 тэрбум төгрөгийн татвар ногдуулсан нь автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн байна.

3.1.17 Татварын бус орлого Тайлант онд 1,199.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1,186.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 13.2 тэрбум төгрөг буюу 1.1 хувиар дутуу биелсэн байна.

3.1.18 Татварын бус орлого тасрахад хувьцааны ногдол ашгийн орлого 7.7 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 28.7 тэрбум төгрөгөөр тус тус тасарсан нь голлон нөлөөлжээ.

3.1.19 Татварын бус орлогын гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт № 20/

/тэрбум төгрөг/

Д/д	Татварын бус орлогын төрөл	2016 оны гүйц	2017 он			
			Төлөв	Гүйцэт	Зөрүү	Хувь
1	Хувьцааны ногдол ашиг	3.3	18.8	11.1	-7.7	59.0
2	Төсөвт байгууллагын өөрийн орлого	230.2	318.0	289.3	-28.7	91.0
3	Тусламжийн орлого	337.9	468.0	448.4	-19.6	95.8

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

3.1.20 Ногдол ашгийн орлогыг дараах байгууллагууд дутуу төвлөрүүлсэн байна. Үүнд:

Ногдол ашгийн орлого Тус орлогоор 18.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 11.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 7.7 тэрбум төгрөгийн орлого дутуу биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна.

- ТӨБЗГ зарим төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ашгаас ногдол ашиг тооцоогүй буюу дутуу тооцсон. Тухайлбал, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ногдол ашгийг 694.4 сая, “Монгол шуудан” ХК-ийн ногдол ашгийг 104.0 сая төгрөгөөр тус тус дутуу ногдуулсан, “Багануур” ХК, “Шивээ овоо” ХК, “Эрдэнэс таван толгой” ХК, “Төрийн банк” ХХК зэрэг байгууллагуудын ашгаас тус тус ногдол ашиг тооцож, ногдуулалт хийгээгүй,
- 2017 оны улсын төсвийн орлогод төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын төлөвлөгөөнөөс ногдуулалт 6.0 тэрбум төгрөгөөр дутуу буюу орлого төвлөрүүлэх байгууллага тодорхойгүй байгаа зэрэг нь орлого дутуу биелэхэд нөлөөлсөн байна.

/Хүснэгт №21/

/сая.төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
1	Диспетчерийн үндэсний төв ХХК	1,006.7	-	-	1,006.7
2	БЗӨБЦТС ХК	950.1	74.5	7.8	875.6
3	ХАА-н давхар даатгал ХК	832.6	-	-	832.6
4	УБЦТС ХК	1,660.3	1,000.0	60.2	660.3
5	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	10.2	-	-	10.2
6	Монголын цахилгаан холбоо ХК	7.2	-	-	7.2
7	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв ТӨҮГ	6.0	-	-	6.0
Нийт		4,473.1	1,074.5	24.0	3,398.6

Эх сурвалж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын мэдээлэлд суурилав.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 8.5 хувиар буюу 24.6 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь ХХААХҮС 16.4 тэрбум, ХНХС 10.2 тэрбум, БХС 5.5 тэрбум, бусад ТЕЗ 2.5 тэрбум төгрөгийн орлогыг тус тус дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн улсын төсөвт төвлөрүүлэх орлого тасарсан нь харилцаа, холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн ашгаас төвлөрүүлэх орлогыг 0.4 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Тусламжийн орлогын төлөвлөгөө 4.2 хувиар буюу 19.6 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь ТЕЗ-дын гадаад төслөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн нэгжүүдийн төлөвлөсөн санхүүжилт тайлант ондоо багтаж олгогдоогүй, он дамжин олгогдсон нь голлон нөлөөлсөн байна.

ТАТВАРЫН ЗАРЛАГА

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

3.1.21 Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2017 оны гүйцэтгэлээр 883.4 тэрбум төгрөг буюу татварын орлогын 13.9 хувьд хүрсэн байна.

3.1.22 Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиудын хүрээнд 2017 онд 5,429 иргэн, хуулийн этгээдийг импортын барааны гаалийн болон НӨАТ-аас чөлөөлсөн байна.

3.1.23 ААНОАТ-ын тухай хуулийн хүрээнд 626 хуулийн этгээд, НӨАТ-ын тухай хуулийн хүрээнд 5429 иргэн, хуулийн этгээд, ХХОАТ-ын тухай хуулийн хүрээнд давхардсан тоогоор 920.9 мянган иргэн тус тус татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан байна.

3.1.24 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ, бүтцийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №22/

/тэрбум.төгрөг/

№	Үзүүлэлт	2016 он	2017 он	Бүтэц хувиар
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт		908.3	883.4	100.0
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	296.6	273.2	30.9
2	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль	251.0	234.0	26.5
3	Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хууль, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль	45.7	55.0	6.2
4	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль	121.3	125.5	14.2
5	Онцгой албан татварын тухай хууль	193.7	195.7	22.2

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

3.1.25 Тайлант оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн нийт дүн өмнөх оноос 24.9 тэрбум төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

3.2 Улсын төсвийн зарлага

3.2.1 Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн зарлагыг 7,420.6 тэрбум төгрөгөөр баталсан нь анх баталснаас 661.4 тэрбум, 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан тодотголоос 460.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь урсгал зарлагыг 7.9 тэрбум, хөрөнгийн зардлыг 438.7 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардлыг 214.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.2.2 Тайлант онд улсын төсвийн зарлага 7,139.6 тэрбум төгрөг буюу 96.2 хувийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөснөөс 281.0 тэрбум төгрөгийн дутуу биелэлттэй байна.

/Хүснэгт №23/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2016 оны гүйц	2017 оны				Дүнд эзлэх хувь
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү	
А	1	3	4	5=4/3	6=4-3	7
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,394.2	7,420.6	7,139.6	96.2	-281.0	100.0
А. Урсгал зарлага	4,993.1	5,663.7	5,524.2	97.5	-139.5	77.4
Бараа, үйлчилгээний зардал	1,951.1	2,001.8	1,901.8	95.0	-100.0	26.6
Хүү	926.3	1,156.7	1,156.5	100.0	-0.2	16.2
Татаас ба урсгал шилжүүлэг	2,115.7	2,505.2	2,465.9	98.4	-39.3	34.6
Б. Хөрөнгийн зардал	1,893.3	1,447.9	1,322.4	91.3	-125.5	18.5
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	507.8	309.0	293.0	94.8	-16.0	4.1

3.2.3 Нийт зарлагын 77.4 хувь буюу 5,524.2 тэрбум төгрөгийг урсгал зардалд, 18.5 хувь буюу 1,322.4 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд, 4.1 хувь буюу 293.0 тэрбум төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлд зарцуулсан байна.

3.2.4 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 291.2 тэрбум төгрөг буюу 95.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь өмнөх оноос 257.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хүний хөгжил сангийн тухай хууль хүчингүй болж, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг халамжийн сангаас олгох болсонтой холбоотой байна.

3.2.5 Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2016 онд босго шугамаас доогуур эрэмбэлэгдсэн хүүхдүүдэд, 2017 онд нийт өрхийн 40 хувийг хамруулан олгож байсан бол Засгийн газрын 2017 оны 201 дүгээр тогтоолын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт өрхийн бүх хүүхдэд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож нөхөн олгоход 104.5 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэн тодотгосон байна.

3.2.6 Хүүгийн зардал: Тайлант онд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт нийт 1,156.7 тэрбум төгрөгийг төлөхөөр төлөвлөж, 1,156.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарснаас

гадаад өрийн хүүгийн төлбөрт 548.0 тэрбум, дотоод зээл, үнэт цаасны хүүгийн төлбөрт 608.5 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

3.2.7 Гадаад зээлийн хүүгийн төлбөрт 113.6 тэрбум, гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрт 408.5 тэрбум, гэрээнд заасан бусад төлбөрийн үүрэг, хураамжид 25.9 тэрбум, нийт 548.0 тэрбум төгрөгийг гадаад өрийн үйлчилгээний төлбөрт төлсөн байна.

3.2.8 Тусгай зориулалтын болон улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүүгийн зардал, хөнгөлөлтийн төлбөрт нийт 505.5 тэрбум төгрөгийг төлжээ. Тухайлбал,

- “Орон сууц” хөтөлбөрт гаргасан үнэт цаасны хүүгийн зардал 0.2 тэрбум,
- “Сайн хөтөлбөр”-үүдийн хүүгийн зардал 5.0 тэрбум,
- Улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүү 243.2 тэрбум, хөнгөлөлтийн төлбөр 257.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

3.2.9 Векселийн хүүгийн төлбөрт 46.0 тэрбум төгрөгийг төлсөн байна. Үүнд: Төмөр замын векселийн хүүд 45.5 тэрбум, хөрөнгө оруулалтын векселийн хүүд 0.5 тэрбум төгрөгийг төлсөн байна.

3.2.10 Хүний хөгжил сангаас төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүү 45.2 тэрбум, хөнгөлөлтийн төлбөр 11.8 тэрбум, нийт 57.0 тэрбум төгрөг төлжээ.

3.2.11 Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар 31 ТЕЗ-ийн 2017 онд хэрэгжүүлэх 86 хөтөлбөрт хамаарах 331 арга хэмжээ, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүдийг баталсан байна.

3.2.12 ТЕЗ-дын 2017 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй харьцуулан тайлагнах асуудал хангалтгүй, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.2.13 Нэгтгэсэн хөтөлбөр, арга хэмжээ тус бүрийн батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг ТЕЗ-аар тайлагнасан боловч түүнд хөтөлбөр, арга хэмжээнд хамаарах төсөв, гүйцэтгэлийн дүнг арга хэмжээ тус бүрээр иж бүрэн гаргаж, нэгтгэн дүгнээгүй, 2017 оны зорилтот түвшний хэрэгжилт тасарсан болон давуулан биелүүлсэн шалтгааныг дурдаагүй байна.

3.2.14 Энэ нь эдийн засгийн ангиллаар гаргасан төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлтэй уялдуулан тайлагнах журам, арга зүй хангалтгүй байна.

3.3 Улсын төсвийн тэнцэл

3.3.1 2017 онд улсын төсвийн нийт тэнцлийг 2,693.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,965.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1.8 дахин буурсан байна.

3.3.2 Улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор тайлант онд 6,589.2 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалж, 2,200.9 тэрбум төгрөгийн гадаад зээл авч, Тогтворжуулалтын сангаас 572.1 тэрбум төгрөг, Ирээдүйн өв сангаас 160.0 тэрбум төгрөг тус тус шилжүүлж, өмч хувьчлалаас 17.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

3.3.3 Дээрх эх үүсвэрүүдээс ЗГҮЦ-ны эргэн төлөлтөд 6,382.6 тэрбум, Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтөд 165.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, Ирээдүйн өв сангийн 196.9 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулж 1,965.9 тэрбум төгрөгөөр 2017 оны улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлснээр харилцах болон хадгаламжийн дансдын үлдэгдэл 755.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН 2017 ОНЫ ТӨСӨВ**4.1 Орон нутгийн төсвийн орлого**

4.1.1 Орон нутгийн 2017 оны төсвийн орлогыг 2,375.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 2,437.2 тэрбум төгрөгт хүрч, 2.6 хувь буюу 61.7 тэрбум төгрөгөөр давуулан, өмнөх оноос 12.3 хувь буюу 267.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Орон нутгийн 2017 оны төсвийн орлогыг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт №24/ /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2016 оны гүйц	2017 оны			
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	2,169.7	2,375.5	2,437.2	102.6	61.7
Урсгал орлого	901.2	1,104.4	1,165.2	105.5	60.8
Татварын орлого	799.5	947.8	1,006.6	106.2	58.8
Татварын бус орлого	101.7	156.6	158.6	101.3	2.0
Хөрөнгийн орлого	1.2	1.2	1.2	100.0	-
Тусламжийн орлого	1,267.3	1,269.9	1,270.8	100.1	0.9

4.1.2 Орон нутгийн татварын орлого 6.2 хувиар буюу 58.8 тэрбум, татварын бус орлого 1.3 хувиар буюу 2.0 тэрбум, тусламжийн орлого 0.1 хувиар буюу 0.9 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

4.1.3 Тайлант онд улсын төсвөөс орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэг 146.2 тэрбум, ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 53.0 тэрбум, тусгай зориулалтын шилжүүлэг 1,066.1 тэрбум, нийт 1,265.3 тэрбум төгрөгийг олгосон бөгөөд орон нутгийн суурь орлого 1,171.9 тэрбум төгрөг байна.

/График №5/



4.1.4 Аймаг, нийслэлийн төсвийн 2017 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

/Хүснэгт № 25/ /тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Орлого				Аймаг, нийслэл	Орлого			
	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Архангай	66.0	66.0	100.1	0.1	Сүхбаатар	48.0	48.1	100.1	0.1
Баян-Өлгий	71.1	71.8	100.9	0.7	Сэлэнгэ	74.3	76.4	102.9	2.1
Баянхонгор	66.6	66.6	100.0	0.0	Төв	69.2	71.2	102.9	2.0
Булган	52.9	54.7	103.4	1.8	Увс	62.2	62.8	100.9	0.6
Говь-Алтай	51.2	52.1	101.8	0.9	Ховд	62.0	62.6	101.1	0.6
Дорноговь	56.7	56.2	99.1	(0.5)	Хөвсгөл	88.5	90.5	102.3	2.0
Дорнод	52.6	55.6	105.8	3.0	Хэнтий	55.0	57.4	104.4	2.4
Дундговь	39.1	39.3	100.5	0.2	Дархан-Уул	56.8	57.4	101.1	0.6
Завхан	59.7	60.5	101.5	0.8	Улаанбаатар	1,040.5	1,065.1	102.4	24.6
Өвөрхангай	74.7	74.6	99.8	(0.1)	Орхон	81.9	85.8	104.7	3.9
Өмнөговь	132.6	147.8	111.4	15.2	Говь-Сүмбэр	14.0	14.6	104.4	0.6
Нийт дүн						2,375.5	2,437.2	102.6	61.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

4.1.5 Төсвийн орлогын төлөвлөгөөг 0.6 тэрбум төгрөгөөр тасалсан нь Дорноговь, Өвөрхангай аймаг татварын бус орлогыг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

4.2 Орон нутгийн төсвийн зарлага

4.2.1 Тайлант оны орон нутгийн төсвийн нийт зарлага 2,623.5 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 2,437.1 тэрбум төгрөг зарцуулж, 92.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

4.2.2 Орон нутгийн төсвийн зарлагын эдийн засгийн ангиллаар харуулбал:

/Хүснэгт № 26/

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2016 оны гүйц	2017 оны			
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,330.4	2,623.5	2,437.1	92.9	(186.4)
А. Урсгал зардал	1,853.0	2,121.6	2,078.3	98.0	(43.3)
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,323.8	1,414.2	1,383.7	97.8	(30.5)
Татаас	84.6	92.6	92.1	99.5	(0.5)
Урсгал шилжүүлэг	444.6	614.8	602.5	98.0	(12.3)
Б. Хөрөнгийн зардал	463.9	457.1	335.7	73.4	(121.4)
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	13.5	44.8	23.1	51.6	(21.7)

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэлд суурилав.

4.2.3 Орон нутгийн төсвийн нийт зарлагын 85.3 хувь буюу 2,078.3 тэрбум төгрөгийг урсгал зарлага, 13.8 хувь буюу 335.7 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал, 0.9 хувь буюу 23.1 тэрбум төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал эзэлж байна.

4.2.4 Орон нутгийн төсвийн нийт зарлагын дүнг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал 106.7 тэрбум төгрөг буюу 4.6 хувиар, урсгал зарлага 225.3 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал 9.6 тэрбум төгрөг буюу 71.2 хувиар тус тус өссөн бөгөөд хөрөнгийн зардал 128.2 тэрбум төгрөг буюу 27.6 хувиар буурсан байна.

4.2.5 Урсгал зарлага өмнөх оноос 225.3 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар өссөн шалтгааныг тодруулбал:

- Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого өмнөх оноос 120.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 195.5 тэрбум төгрөгт хүрсэн,
- УИХ-ын 2017 оны 11 сарын 09-ний өдрийн 67 дугаар тогтоолын дагуу “Төрийн албан хаагчдад 300.0 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох” шийдвэр гарч урамшуулал олгосон,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “...ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь авч байсан албан тушаалын 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно” гэж заасныг үндэслэн орон нутгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн үр дүнд ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагч 1,786 албан тушаалтанд 7.1 тэрбум төгрөгийг олгосон байна.

4.2.6 Хөрөнгийн зардал өмнөх оноос 128.2 тэрбум төгрөгөөр буурч 335.7 тэрбум төгрөгт хүрч, нийт зарлагын 13.8 хувийг эзэлж байна.

4.2.7 Орон нутгийн ТЕЗ, түүний харьяа зарим байгууллагууд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁹, 16 дугаар зүйлийн 16.5.5²⁰, 42 дугаар зүйлийн 42.7²¹ дахь заалт, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 15²² дахь заалтыг мөрдөөгүйгээс аймаг, нийслэлийн хэмжээнд төсвийг үр ашигтай, зөв зохистой зарцуулаагүй нийт 4.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

Төсвийн тухай хууль болон төсвийн хэмнэлтийн талаар гарсан тогтоол, шийдвэр, журмын хэрэгжилт хангалтгүйгээс Нийслэл 3.8 тэрбум, Хөвсгөл 0.2 тэрбум, Сэлэнгэ 0.1 тэрбум, Говьсүмбэр 0.1 тэрбум, Өвөрхангай 0.1 тэрбум, бусад аймаг 0.1 тэрбум төгрөгийг төсвийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

4.2.8 Аймаг, нийслэлийн төсвийн 2017 оны зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

¹⁹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

²⁰ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

²¹ Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

²² “Энэ журмыг 2.1, 2.2 дахь заалтад зааснаас бусад зориулалтаар Засаг даргын нөөц хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зардал гаргах, олгосон хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно”

/Хүснэгт № 27/

/тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Зарлага				Аймаг, нийслэл	Зарлага			
	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Архангай	69.5	66.8	96.1	(2.7)	Сүхбаатар	53.2	51.0	95.9	(2.2)
Баян-Өлгий	72.6	71.3	98.3	(1.3)	Сэлэнгэ	78.9	76.8	97.4	(2.1)
Баянхонгор	69.6	67.3	96.7	(2.3)	Төв	80.2	75.2	93.8	(5.0)
Булган	57.9	53.9	93.2	(4.0)	Увс	65.0	63.4	97.4	(1.6)
Говь-Алтай	55.3	54.0	97.8	(1.3)	Ховд	63.1	61.6	97.7	(1.5)
Дорноговь	57.9	56.0	96.8	(1.9)	Хөвсгөл	94.1	91.3	97.0	(2.8)
Дорнод	56.5	55.5	98.2	(1.0)	Хэнтий	59.0	56.9	96.4	(2.1)
Дундговь	42.3	40.0	94.5	(2.3)	Дархан-Уул	71.5	64.6	90.4	(6.9)
Завхан	63.3	61.4	96.9	(1.9)	Улаанбаатар	1,181.1	1,075.1	91.0	(106.0)
Өвөрхангай	77.0	74.5	96.7	(2.5)	Орхон	93.0	89.1	95.9	(3.8)
Өмнөговь	145.7	116.5	79.9	(29.2)	Говьсүмбэр	16.8	14.7	87.5	(2.1)
Нийт дүн						2,623.5	2,437.1	92.9	(186.4)

4.2.9 Орон нутгийн төсвийн нийт зарлага 92.9 хувь буюу 2,437.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 186.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

4.2.10 Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 195.6 тэрбум төгрөгөөр баталснаас Нийслэл, Өмнөговь, Орхон, Булган, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр аймгууд 195.4 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, Дорноговь аймаг улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 0.2 тэрбум төгрөгөөр тасалсныг аудитын явцад улсын төсөвт төлүүлэв.

4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл

4.3.1 2017 онд орон нутгийн төсвийн нийт тэнцлийг 248.0 тэрбум төгрөгийн алдагдалтайгаар төлөвлөж, гүйцэтгэлээр 0.1 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

4.3.2 Орон нутгийн 2017 оны төсвийн нийт тэнцлийн алдагдлыг Засгийн газрын гадаад зээлээс 47.3 тэрбум, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 195.6 тэрбум, өмч хувьчлалын орлогоос 5.1 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 28.7 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашиглаж, өмч хувьчлалын орлогоос 5.1 тэрбум төгрөг оруулж, тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 33.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

4.3.3 Тайлант онд орон нутгийн төсвийн нийт тэнцэл 0.1 тэрбум төгрөгийн ашигтай гарахад нийслэл болон нэр бүхий 14 аймаг 34.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, 8 аймаг 34.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь нөлөөлжээ.

БҮЛЭГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСӨВ**5.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого**

5.1.1 Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 1,467.9 тэрбум төгрөгөөр баталж, 1,544.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 105.2 хувиар буюу 76.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Орлогын төрлөөр харуулбал:

/Хүснэгт №28/		/тэрбум төгрөг/			
№	Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	834.6	880.3	105.5	45.7
2	Тэтгэмжийн даатгал	103.1	112.7	109.3	9.6
3	ҮОМШӨ-ний даатгал	136.2	147.9	108.6	11.7
4	Ажилгүйдлийн даатгал	37.6	39.0	103.7	1.4
5	Эрүүл мэндийн даатгал	356.4	364.1	102.2	7.7
	Дүн	1,467.9	1,544.0	105.2	76.1
6	Улсын төсвөөс санхүүжих	570.2	570.2	100.0	0.0
	Нийт дүн	2,038.1	2,114.2	103.7	76.1

5.1.2 Сангийн нийт орлого 76.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь 2017 онд ажил олгогчийн тоо өмнөх оноос 458, даатгуулагчийн тоо 37.0 мянган хүнээр тус тус нэмэгдсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 240.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон зэргээс шалтгаалж 39.4 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн түвшин 9 хувийг 2016 оны эцсээр 15 хувь хүргэж нэмэгдүүлснээр хүүгийн орлого 36.7 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

5.1.3 НДС 2017 онд улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт 463.9 тэрбум, цэргийн тэтгэвэрт 106.3 тэрбум, нийт 570.2 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.

5.1.4 Тайлант онд НДС-ийн нийт 1,097.6 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 450.5 тэрбум төгрөгийг арилжааны банкинд байршуулсан нь өмнөх оноос 22.7 хувь буюу 132.4 тэрбум төгрөгөөр буурч, нийт мөнгөн хөрөнгийн 41.0 хувийг эзэлж байна. Энэ нь тайлант онд 9 банкны 638.0 тэрбум төгрөгийн хадгаламжийн гэрээ дуусгавар болж, 7 банкны 441.6 тэрбум төгрөгийн хадгаламжийг сунгаж, 164.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрээр 6 банкинд шинээр байршуулсантай холбоотой байна.

5.1.5 Тайлант онд харилцах дансны үлдэгдэл, хадгаламж, бондын хүүгээс 108.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлжээ.

5.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага

5.2.1 Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулиар зарлагыг 1,907.5 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,890.9 тэрбум төгрөгийг зарцуулж, 16.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Харин Нийслэлийн НДС 8.4 тэрбум, Орхон аймгийн НДС 0.7 тэрбум, Сэлэнгэ аймгийн НДС 0.7 тэрбум төгрөгөөр тус тус төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

5.2.2 НДС-аас тайлант онд давхардсан тоогоор 6,820.5 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд 1,890.9 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Зардлын гүйцэтгэлийг харуулбал,

/Хүснэгт №29/

/тэрбум төгрөг/

Ангилал		2016 оны гүйц	2017 он			
			Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	1,320.6	1,404.4	1,417.4	100.9	13.0
2	Тэтгэмжийн даатгал	94.1	102.0	100.2	98.2	-1.8
3	ҮОМШӨ-ний даатгал	31.0	48.2	46.0	95.4	-2.3
4	Ажилгүйдлийн даатгал	32.0	35.9	35.1	97.8	-0.8
5	Эрүүл мэндийн даатгал	242.8	317.0	292.2	92.2	-24.8
Дүн		1,720.5	1,907.5	1,890.9	99.1	-16.6

5.2.3 Тайлант онд төсвийг 0.9 хувь буюу 16.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсан ба тэтгэврийн даатгалын сангаас бусад сангууд төлөвлөгөөг 1.8-7.8 хувиар хэмнэсэн үзүүлэлттэй байна.

5.2.4 Тэтгэврийн даатгалын санд 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт болон цэргийн тэтгэвэрт нийт 570.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосноор өмнөх жилүүдэд алдагдалтай байсан тус сан 2017 онд 33.1 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

5.2.5 Тэтгэврийн даатгалын сан алдагдалтай ажиллахад голлон нөлөөлсөн шалтгааныг дурдвал:

- Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, “Тэтгэвэр нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2015 оны 52, 2016 оны 292 дугаар тогтоолуудын дагуу иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэн тэтгэврийн доод хэмжээ 140.3-251.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 105.2-216.0 мянган төгрөг, дундаж тэтгэвэр 162.0-310.7 мянган төгрөгт хүрч тус тус нэмэгдсэн.
- Тэтгэврийн даатгалын сангаас 2016 онд 363.8 мянган тэтгэвэр авагчид 1,320.6 тэрбум, 2017 онд 387.8 мянган тэтгэвэр авагчид 1,417.4 тэрбум төгрөг тус тус зарцуулж, тус сангийн зарлага 5.9-12.7 хувиар өссөн байна.

5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл

5.3.1 НДС-ийн төсвийн тэнцлийг 2017 онд 130.6 тэрбум төгрөгийн алдагдалтай төлөвлөж, гүйцэтгэлээр 223.4 тэрбум төгрөгийн ашигтай гарч, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсч 1,097.6 тэрбум төгрөг болсон байна.

БҮЛЭГ 6. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

6.1 Тайлант онд нэмэлт төсвөөр 327.5 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оноос 53.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 322.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

6.2 Нийт эх үүсвэрийн 202.3 тэрбум төгрөг буюу 62.0 хувь нь төсвийн эх үүсвэрээс, 124.3 тэрбум төгрөг буюу 38.0 хувь нь төсвийн бус эх үүсвэрээс санхүүжигдсэн байна.

6.3 Нэмэлт төсвийн төвлөрсөн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.2-т зааснаар ангилан харуулбал:

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 21.9 тэрбум,
- УИХ-аас баталсан Засгийн газар хоорондын гэрээ болон Олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл 9.9 тэрбум,
- Засгийн газрын болон Засаг даргын нөөцөөс 72.5 тэрбум,
- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 129.8 тэрбум,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 92.5 тэрбум төгрөг байна.

6.4 Нэмэлт төсвөөр 2017 онд бүрдүүлсэн эх үүсвэр болон мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс нийт 322.2 тэрбум төгрөгийг зарцуулснаас улсын төсөвт байгууллагууд 243.3 тэрбум төгрөг буюу 75.6 хувь, орон нутгийн төсөвт байгууллагууд 78.9 тэрбум төгрөг буюу 24.4 хувийг тус тус эзэлж байна.

6.5 Нэмэлт төсвөөс бараа, ажил үйлчилгээний нийт зардалд 256.6 тэрбум, татаас ба урсгал шилжүүлэгт 51.2 тэрбум, хөрөнгийн зардалд 14.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

6.6 Нэмэлт төсвөөс бараа, ажил үйлчилгээний зардалд 83.6 тэрбум төгрөг зарцуулснаас эд хогшил, урсгал засварт 18.6 тэрбум, томилолт, зочны зардалд 44.6 тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 76.3 тэрбум, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 11.0 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

6.7 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын нэмэлт төсвийн 15.7 хувь буюу 49.8 тэрбум төгрөгийг БХС, 9.7 хувь буюу 30.8 тэрбум төгрөгийг ЭХС, 8.3 хувь буюу 26.4 тэрбум төгрөгийг Шадар сайд, 6.8 хувь буюу 21.5 тэрбум төгрөгийг ХЗДХС, 6.5 хувь буюу 20.5 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн сайд тус тус зарцуулсан байна.

6.8 Орон нутгийн нэмэлт төсвийн нийт зарцуулалтын 38.8 хувь буюу 30.6 тэрбум төгрөг Нийслэлд, 6.9 хувь буюу 5.4 тэрбум төгрөг Өмнөговь, 5.4 хувь буюу 4.2 тэрбум төгрөг Өвөрхангай, 48.9 хувь буюу 38.7 тэрбум төгрөг бусад аймагт ногдож байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 4, Сангийн сайдад 4, нийт 8 зөвлөмж өгсөн болно. Зөвлөмжийн биелэлтийг Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 13-2/1652 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлснийг хянахад зөвлөмжийн 3 нь дутуу хэрэгжсэн, 3 нь хэрэгжих шатандаа, 2 нь хэрэгжээгүй байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Засгийн газраас ирүүлсэн Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 7,958.3 тэрбум төгрөгийн нийт орлого ба тусламж, 9,017.3 тэрбум төгрөгийн нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.
2. Олон улсын зах зээлийн эерэг хандлага, эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн өсөлт, зэрэг гадаад хүчин зүйлсээс гадна ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан, төлбөрийн тэнцэл сайжирч, валютын нөөц нэмэгдсэн, ам.долларын ханш тогтворжсон, бодит эдийн засаг өссөн зэрэг дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөр нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж төлөвлөснөөс 698.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
3. Төсвийн тэлэлтийг хумих, мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг нэмэгдүүлэх, хүүгийн зардлын ачааллыг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн бодлогын нөлөөгөөр төлөвлөснөөс нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл 477.1 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 3.1 нэгж хувиар тус тус буурсан байна.
4. Төсвийн алдагдлыг өмнөх жилүүдэд өндөр хүүтэй богино хугацаатай зээллэгээр санхүүжүүлж өрийн дарамтад орох эрсдэл үүссэнийг ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй эх үүсвэрээр төсвийн алдагдлыг нөхөж, Засгийн газрын өндөр хүүтэй дотоод үнэт цаас гаргалтыг зогсоосон нь өрийн бүтцэд гадаад өрийн эзлэх хувь өсч, дотоод өрийн эзлэх хувь буурахад нөлөөлжээ.
5. ТХМ-ийг макро эдийн засгийн дунд хугацааны төсөөлөл, гадаад, дотоод хүчин зүйлсийг үндэслэлтэй тооцоолон баталж, төсөвт нэмэлт өөрчлөлт оруулахдаа батлагдсан хуулийг өөрчлөх бус тууштай хэрэгжүүлэх талаар өмнөх онд Үндэсний аудитын газраас Засгийн газарт өгсөн зөвлөмж болон Улсын Их Хурлын анхааралд толилуулсан асуудлыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
6. Тайлант оны дундуур хүүхдийн мөнгөн тэтгэмжийг оны эхнээс бүх хүүхдэд олгох талаар Засгийн газраас шийдвэрлэсэн нь төсвийн төсөлд тусгагдаагүй зардал нэмэгдэхэд нөлөөлсөн байна.
7. Нэгдсэн төсвийн 2017 оны нийт алдагдал ДНБ-ийн 6.4 хувьтай тэнцэж, алдагдлыг санхүүжүүлсэн өрийн өсөлттэй холбоотойгоор хүүгийн зардал 1,156.5 тэрбум төгрөгт хүрч, нийт зарлагын 12.8 хувьтай тэнцэж байгаа нь Монгол Улс төсвийн болон төлбөрийн чадварын эрсдэлтэй хэвээр байна.
8. Татварын ерөнхий газар НӨАТ-ын буцаан олголтын тооцоололд хяналт хийж баталгаажуулахдаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон Сангийн сайдын 2015 оны 333 дугаар тушаалаар баталсан журамд заасан хугацааг баримтлаагүй байна.
9. ТӨБЗГ улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн ногдуулалтыг Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар батлагдсанаас 6.0 тэрбум төгрөгөөр дутуу баталсан, зарим төрийн өмчит ААНБ-ын ногдол ашгийн орлогыг дутуу тооцсон, 2016 онд ашигтай ажилласан зарим төрийн өмчит ААНБ-ын ашгаас ногдол ашиг төвлөрүүлэхээр тооцоогүй зэрэг нь улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын төлөвлөгөө тасрах шалтгаан болжээ.

10. Төсвийг хөтөлбөрөөр төлөвлөж, үр дүнг тооцож хэрэгжүүлэх үйл ажиллагаа жигд бус, төлөвлөлт, бүртгэл тооцоо, тайлагналын програм хангамжийн уялдаа хангалтгүй байгаагаас ТЭЗ-дын төсвийн гүйцэтгэлийн тайлагнал, хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдахгүй байна.
11. ТЭЗ-д нь тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж зохицуулалт хийсэн гүйцэтгэлээ анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнаагүй байна.
12. Нэмэлт төсвийн гүйцэтгэл 322.2 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн зарлагын 3.6 хувьтай тэнцэж байна.
13. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2-т “УИХ-аас баталсан Засгийн газар хоорондын гэрээ болон Олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл” гэж тодорхойлсон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэж заасан зарчимтай нийцэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд-д

1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бодитой тооцож батлуулах, төсвийн төлөвлөлт, тодотголд түүнийг тууштай баримтлах;
2. Жилийн дундуур төсөвт нөлөөлөх талаар гаргасан бодлогын шийдвэрийг дараагийн жилээс хэрэгжүүлдэг байх талаар хуулийн заалтыг тогтвортой мөрдөх;
3. Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалтыг мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан зарчимтай нийцүүлэх талаар хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж батлуулах;

Сангийн сайд-д

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын програм хоорондын мэдээлэл солилцох боломж нөхцөлийг нэмэгдүүлэх замаар төлөвлөлт, санхүүжилт, тайлан бүртгэлийн мэдээллийн системүүдийн ач холбогдол, үр нөлөөг дээшлүүлэх, тэдгээрийн уялдааг хангах ажлыг эрчимжүүлэх талаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;
2. Мөнгөн хөрөнгийн удирдлага, урт хугацааны төсвийн дарамтын нөлөөлөл, өрийн тогтвортой байдал, болзошгүй өр төлбөр зэргийг сайтар тооцож, зээл авах, үнэт цаас гаргах асуудлыг шийдвэрлэж байх;
3. ТЕЗ-ийн хөтөлбөр арга хэмжээний төсвийн гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаарх төсвийн гүйцэтгэлтэй уялдуулах арга аргачлалыг тусгасан журам боловсруулж хэрэгжүүлэх;
4. Орон нутгийн төсвийн суурь зарлагын бодит хэрэгцээ, онцлогт тохирсон норм нормативыг тогтоож, орон нутгийн суурь зарлагыг тооцох аргачлалыг шинэчлэн баталж мөрдүүлэх;
5. Орон нутгийн суурь зарлагын бүрэлдэхүүнд багтдаг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээний зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

Татварын ерөнхий газрын дарга-д

1. НӨАТ-ын буцаан олголтыг хууль, журмын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх;

Хавсралт 1

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	Нэгдсэн			Улсын			Орон Нутгийн			НДС	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,259.5	7,958.3	694.7	5,303.1	5,857.1	554.0	2,375.5	2,437.2	61.6	2,038.2	2,114.2
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	242.4	325.7	83.3	242.4	325.7	83.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДИЙН ӨВ САН	333.3	357.7	24.4	333.3	357.7	24.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,683.8	7,274.9	587.1	4,727.3	5,173.7	446.4	2,375.5	2,437.2	61.6	2,038.2	2,114.2
1 Татварын орлого	5,717.8	6,315.1	597.4	3,527.6	3,987.2	459.6	947.8	1,006.6	58.7	1,468.0	1,544.0
1.1 Орлогын албан татвар	1,354.8	1,613.2	258.4	728.7	962.1	233.5	626.2	651.0	24.9	0.0	0.0
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	626.2	651.0	24.9	0.0	0.0	0.0	626.2	651.0	24.9	0.0	0.0
1.1.2 Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	728.7	962.1	233.5	728.7	962.1	233.5	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,242.3	1,321.4	79.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	1,468.0	1,544.0
1.3 Хөрөнгийн албан татвар	112.6	131.1	18.5	0.0	0.0	0.0	112.6	131.1	18.5	0.0	0.0
1.4 Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,448.5	1,618.5	170.0	1,448.5	1,618.5	170.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.5 Онцгой албан татвар	511.6	519.7	8.1	511.6	519.7	8.1	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.6 Тусгай зориулалтын орлого	11.9	12.4	0.4	11.9	12.4	0.4	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.7 Гадаад үйл ажиллагааны орлого	489.8	512.4	22.6	489.8	512.4	22.6	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.8 Бусад татвар (телбөр, хураамж)	546.2	586.5	40.3	337.1	362.1	25.0	209.0	224.4	15.3	0.0	0.0
2 Татварын бус орлого	966.0	959.7	-10.3	1,199.7	1,186.5	-13.2	1,427.7	1,430.6	2.9	570.2	570.2
2.1 Нийтлэг татварын бус орлого	888.2	896.7	8.5	731.6	738.0	6.4	156.6	158.7	2.1	0.0	0.0
2.2 Хөрөнгийн орлого	1.2	1.2	0.0	0.0	0.0	0.0	1.2	1.2	0.0	0.0	0.0
2.3 Тусламжийн орлого	76.6	61.8	-18.8	468.0	448.4	-19.6	1,269.9	1,270.8	0.8	570.2	570.2

Хавсралт 2

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн			Улсын			Орон нутгийн			НДС		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,494.4	9,017.3	-477.1	7,420.6	7,139.6	-281.0	2,623.5	2,437.1	-186.5	1,907.5	1,890.9	-16.7
А УРСГАЛ ЗАРДАЛ	7,235.7	7,043.2	-192.5	5,663.7	5,524.2	-139.5	2,121.6	2,078.3	-43.3	1,907.5	1,890.9	-16.7
1 Бараа, үйлчилгээний зардал	3,269.5	3,141.4	-128.1	2,001.8	1,901.8	-100.0	1,414.2	1,383.7	-30.5	20.4	20.1	-0.3
1.1 Цалин, хөлс	1,815.4	1,800.4	-14.9	1,016.2	1,004.7	-11.5	784.1	780.7	-3.4	15.1	15.0	-0.1
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	78.7	76.7	-2.0	86.6	85.8	-0.7	1.7	1.7	0.0
1.3 Бараа, үйлчилгээний бусад зардал	1,454.1	1,341.0	-113.1	906.9	820.4	-86.5	543.6	517.1	-26.4	3.7	3.5	-0.2
2 ХҮҮ	1,156.7	1,156.5	-0.2	1,156.7	1,156.5	-0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3 Татаас ба урсгал шилжүүлэг	2,809.5	2,745.3	-64.2	2,505.3	2,466.0	-39.3	707.4	694.6	-12.8	1,887.1	1,870.7	-16.4
3.1 Татаас	289.1	207.3	-81.8	652.1	647.8	-4.3	92.6	92.1	-0.5	114.6	114.6	0.0
3.2 Урсгал шилжүүлэг	2,520.4	2,537.9	17.6	1,853.2	1,818.2	-35.0	614.8	602.6	-12.3	1,772.5	1,833.0	60.5
Б ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,904.9	1,658.1	-246.8	1,447.9	1,322.4	-125.4	457.1	335.7	-121.4	0.0	0.0	0.0
1 Барилга байгууламж	1,260.9	1,121.7	-139.2	995.7	929.9	-65.8	265.2	191.7	-73.5	0.0	0.0	0.0
2 Их засвар	76.6	67.0	-9.6	68.1	59.2	-8.9	8.4	7.7	-0.7	0.0	0.0	0.0
3 Хөрөнгийн бусад зардал	567.5	469.5	-98.0	384.0	333.3	-50.8	183.4	136.2	-47.2	0.0	0.0	0.0
В ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	353.8	316.0	-37.8	309.0	293.0	-16.1	44.8	23.1	-21.7	0.0	0.0	0.0
1 Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	180.3	200.8	20.5	145.7	183.5	37.8	34.6	17.3	-17.3	0.0	0.0	0.0
2 Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	173.5	115.2	-58.3	163.3	109.5	-53.8	10.2	5.7	-4.5	0.0	0.0	0.0

Хавсралт 3

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

	Нэгдсэн		Улсын		Орон нутгийн		НДС					
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл Зөрүү				
ҮЗҮҮЛЭЛТ												
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,259.5	7,958.3	698.7	5,303.1	5,857.1	554.0	2,375.5	2,437.2	61.6	2,038.2	2,111.4	73.2
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	242.4	325.7	83.3	242.4	325.7	83.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	333.3	357.7	24.4	333.3	357.7	24.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,683.8	7,274.9	591.1	4,727.3	5,173.7	446.4	2,375.5	2,437.2	61.6	2,038.2	2,111.4	73.2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,494.4	9,017.3	-477.1	7,420.6	7,139.6	-281.0	2,623.5	2,437.1	-186.5	1,907.5	1,890.9	-16.7
ТЭНЦЭЛ:	-2,810.6	-1,742.5	1,068.2	-2,693.3	-1,966.0	727.4	-248.0	0.1	248.1	130.7	223.4	92.7
АЛДАГДЛЫГ САМУУЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР	2,810.6	1,745.2	-1,065.4	2,693.3	1,966.0	-727.4	248.0	-0.1	-248.1	-130.7	-223.4	-92.7
1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	195.6	-1,013.2	-1,208.8	130.7	-755.9	-886.6	195.6	-33.9	-229.5	-130.7	-223.4	-92.7
3 ЗГ-ын бонд	-36.7	206.6	243.3	-36.7	206.6	243.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1 Урт хугацаат	-36.7	206.9	243.6	-36.7	206.9	243.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1 Дотоод	-2,035.2	-2,305.4	-270.2	-2,035.2	-2,305.4	-270.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1.1 Шинээр гаргах	1,752.3	1,759.9	7.6	1,752.3	1,759.9	7.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1.2 Үндсэн төлбөр	-2,787.5	-3,065.3	-277.8	-2,787.5	-3,065.3	-277.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1.3 Худалдаж авах	-1,000.0	-1,000.0	0.0	-1,000.0	-1,000.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2 Гадаад	1,998.5	2,512.3	513.8	1,998.5	2,512.3	513.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2.1 Шинээр гаргах	3,968.5	3,463.1	-505.4	3,968.5	3,463.1	-505.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2.2 Үндсэн төлбөр	-1,970.0	-950.8	1,019.2	-1,970.0	-950.8	1,019.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2 Богино хугацаат	0.0	-0.3	-0.3	0.0	-0.3	-0.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1 Дотоод	0.0	-0.3	-0.3	0.0	-0.3	-0.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.1 Шинээр гаргах	1,366.5	1,366.2	-0.3	1,366.5	1,366.2	-0.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.2 Үндсэн төлбөр	-1,366.5	-1,366.5	0.0	-1,366.5	-1,366.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4 ЗГ-ын зээл	1,907.5	1,794.7	-112.8	1,860.2	1,766.1	-94.2	47.3	28.7	-18.6	0.0	0.0	0.0
4.1 Дотоод	-293.1	-269.6	23.5	-293.1	-269.6	23.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.2 Авлага	173.3	196.9	23.5	173.3	196.9	23.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.2.3 Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	173.3	196.9	23.5	173.3	196.9	23.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.3 Төсвөөс эргэн төлөгдөх	-466.5	-466.5	0.0	-466.5	-466.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.3.2 Төлөх	466.5	-466.5	-932.9	-466.5	-466.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2 Гадаад	2,200.6	2,064.3	-136.3	2,153.3	2,035.7	-117.7	47.3	28.7	-18.6	0.0	0.0	0.0
4.2.1 Төслийн зээл	710.5	586.2	-124.3	663.2	557.6	-105.6	47.3	28.7	-18.6	0.0	0.0	0.0
4.2.1.1 Шинээр авах	878.2	751.5	-126.7	830.9	722.8	-108.1	47.3	28.7	-18.6	0.0	0.0	0.0
4.2.1.2 Үндсэн төлбөр	-167.7	-165.2	2.5	-167.7	-165.2	2.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.2 Хөтөлбөрийн болон төслийн бус зээл	1,490.2	1,478.1	-12.0	1,490.2	1,478.1	-12.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.2.1 Шинээр гаргах	1,490.2	1,478.1	-12.0	1,490.2	1,478.1	-12.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
7 Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	160.0	160.0	0.0	160.0	160.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
8 Тогтворжуулалтын сангийн хуримлагдсан үлдэгдэл	572.1	572.1	0.0	572.1	572.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
9 Өмч хувьчлал	12.1	22.2	10.1	7.0	17.1	10.1	5.1	5.2	0.1	0.0	0.0	0.0



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 08 өдөр

Дугаар A/137

Улаанбаатар хот

Г Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”-г нэгдүгээр хавсралтаар, “Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд нарт тус тус зөвлөсүгэй.


4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт, тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Санхүүгийн аудитын газар /Ц.Наранчимэг/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д ХҮРЭЛБААТАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 06
дугаар сарын 08-ны өдрийн А/37 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТААР ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН ЖАРСААЛ

д/ д	Төлбөр хариуцагч байгууллага	Дугаар		Тогтоосон ажилтан	Төлбөр зөрчлийн товч утга	Актын төлбөрийн дүн /мян.төгрөгөөр/	Албан шаардлагын төлбөрийн дүн /мян.төгрөгөөр/
		Төлбөрийн акт	Албан шаардлага				
1	Монголын цахилгаан холбоо ХК	01/87		Ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор С.Энхтуяа	Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан ногдол ашгийн орлогыг төвлөрүүлээгүй.	7,197.2	
2	ХАА-н давхар даатгал ХК	01/88				832,587.4	
3	Бүх нийтийн үүргийн сан	01/89				441,685.3	
4	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК	01/90				300,000.0	
5	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар		01/218				7,652,338.0
	НИЙТ ДҮН				1,581,469.9	7,652,338.0	

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР